


Бөмбөлөгөн хавхлага доголдсон

2019 оны 3-р сар



Тохиргоо хийхийн тулд даралт дамжуулагчийг салгаж авсан



Тохиргоо хийхийн тулд даралт дамжуулагчийг салгаж авсан

Төхөөрөмж 1 болон Төхөөрөмж 2-оос гарсан шугамууд замдаа нийлж, халуун исэлдүүлэгчийн (ХИ) шугам руу очдог. Төхөөрөмж 2-ын нарийн хэмжүүрийн хэд хэдэн тоноглолд тохиргоо хийх ёстой байсан учир гар хавхлагыг хааж, түгжсэний дараа даралтын трансмиттерийг салгаж авсан.

Төхөөрөмж 2-ыг түгжсэнээс хойш, нэг эсвэл хоёр хоногийн дараа Төхөөрөмж 1-ийн халуун исэлдүүлэгчтэй холбогдсон шугамаас хорт хий гарч эхэлсэн. Төхөөрөмж 1-ээс гарсан материал шугамаар дамжин Төхөөрөмж 2 руу урсган бөгөөд улмаар даралтын трансмиттерийг салгаж авсан хэсгийн хавхлагаар дамжин гадагшилсан.

Хавхлаганы бариул хаалттай байрлалд байна.



Нээлтэй шугам хоолойд хаалт таг байхгүй байна.

Хавхлаганы бариул доголдсоны ба хавхлагыг хаахгүйгээр эргэж байсан.

Бөмбөлөг нээлтэй байрлалд байна.

Үзлэг шалгалтаар хавхлаганы бариул хаалттай байрлалд байсан хэдий ч хавхлаганы доторх бөмбөлөг нээлттэй байрлалд байсныг илрүүлсэн. (Жич: Хавхлаганы бариулыг гараар шалгаж үзэхэд хэвийн ажиллагаатай хавхлага шиг “мэдрэгдсэн”). Азаар хүн бэртэж гэмтээгүй боловч ийм тохиолдол өөр систем дээр үүссэн бол бэртэл гэмтэл учруулах боломжтой байсан.

Та мэдэх үү?

- Ямар ч хавхлага доголдох боломжтой бөгөөд үүнд нөлөөлөх олон янзын шалтгаан бий!
- Хавхлаганы бариул нь хавхлаганы бодит байрлалыг ямагт зөв заахгүй байж болно. Бариул, шилбэ, бөмбөлөг эсвэл суулт доголдсоны улмаас асуудал үүсэх боломжтой.
- Нэг системд үүссэн асуудал өөр системд нөлөөлөх боломжтой тул тухайн системд өөрчлөлт хийгдэх үед түр зуурын хугацаатай байсан ч бусад системийг давхар тооцох ёстой.

Та юу хийж чадах вэ?

- Шугамыг түр хугацаагаар нээх тохиолдолд ч хаалт, таг, бөглөө ашигла.
- Шугам задлах/нээх үйл ажиллагааг гүйцэтгэхдээ тусгай журам мөрд. Хэрэв тухайн журам нь бүрэн тодорхой биш бол шинэчлэн засварлах хэрэгтэй.
- Хоорондоо хамааралтай системүүдийн харилцан нөлөөллийг тооцож, шугамаар материал явуулахын өмнө заавал “газар дээр нь шалган баталгаажуул”.

Бүх хавхлага доголдох боломжтой. Давхар тусгаарлах боломжийг эрэлхийл.